



ТӨВ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА

41111, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272038

2023.12.18 № 33/42

танай _____ -ны № _____ -т

СҮМДҮН ЗАСАГ ДАРГА,
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН
ДАРГА, НЯГТЛАН БОДОГЧ НАРТ

ЗӨВЛӨМЖ ӨГӨХ ТУХАЙ

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” шинэчлэн батлагдаж, Засгийн газрын 2023 оны 12 сарын 13-ны өдрийн 442 дугаар тогтоолоор 2023 оны 301 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт орсон. Үүнийг хэрэглэхтэй холбоотойгоор санхүүгийн зөрчил гарах эрсдэл байгаа тул дараах “ЗӨВЛӨМЖ”-ийг өгч байна.

Дээрх 442 дугаар тогтоолоор журмын

1. 6.3-д “6.3.Төсвийн шууд захирагч энэ журмын 6.6.1.б болон 6.6.2.в-д заасан урамшууллын хэмжээг байгууллагынхаа төсвөөс хамааран тогтоож, Үнэлгээний баг байгуулах шийдвэртээ тусгана.”
2. 6.5. Үнэлгээний баг албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн, үнэлгээний 85-100 оноог “Маш сайн”, 70-85 хүртэлх оноог “Хэвийн”, 70 хүртэлх оноог “Хангалтгүй” үнэлгээний ангилалд хамруулан эрэмбэлнэ.
3. 6.6.2.”Хэвийн үнэлгээний ангилалд хамаарах албан хаагчийн хувьд:
“в).“Маш сайн” ангилалд хамрагдсан төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллын 50 хувиас хэтрэхгүй хэмжээний мөнгөн урамшуулал олгох.”
3. Энэ журам гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь заалтын “40” гэснийг “50” гэж нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь Засгийн газрын 2019 оны 5-р тогтоолын 3-р хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дэх заалтын дагуу албан хаагчийн албан тушаалын

сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна. Энэ хувь хэмжээ нь “Маш сайн” буюу 85-100 оноогоор үнэлэгдсэн албан хаагчдад хамаарна.

Харин “Хэвийн” ангилал буюу 70-85 хүртэлх оноогоор үнэлэгдсэн албан хаагчдын мөнгөн урамшууллын хувьд журмын 6.6.2 “в” дэх заалтын дагуу “Маш сайн” ангилалд хамрагдсан төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллын 50 хувиас хэтрэхгүй хэмжээний мөнгөн урамшуулал олгохыг зөвлөж байна.

Жишээ нь: Төсвийн шууд захирагч нь үнэлгээний баг байгуулах шийдвэртээ “Маш сайн” үнэлгээний мөнгөн урамшууллын хэмжээг **байгууллагынхаа төсвөөс хамааран тогтоож** үндсэн цалингийн 40 хувиар тогтоосон бол “Хэвийн” үнэлгээтэй албан хаагчид олгох мөнгөн урамшууллын хэмжээ үндсэн цалингийн 20 хувиас хэтрэхгүй байна.

Төрийн захиргааны байгууллага дахь төрийн үйлчилгээний албан хаагчдад улирлын мөнгөн урамшуулал олгоходоо Засгийн газрын 2019 оны 5-р тогтоолын 3-р хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг баримталж олгох бөгөөд Засгийн газрын 2023 оны 301 дүгээр журмын 1.4-д “Энэ журмыг төрийн захиргааны байгууллага дахь төрийн үйлчилгээний албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэхэд жишиг байдлаар ашиглаж болно.” гэсэн заалтын дагуу журмын 6.6-д заасан арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт болон байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлж болно.

ДАРГА



Б.САРУУЛ